

НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



НАЛАЙХ ДҮҮРГИЙН
ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

2018/10



2018 ОН

АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ, 2014-2018 ОН	2-3
 ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ	4
 ИРГЭНИЙ БҮРТГЭЛ	5-6
 НИЙГМИЙН ДААТГАЛ	7-8
 НИЙГМИЙН ХАЛАМЖ	8-9
 ЭРҮҮЛ МЭНД	9-11
 СОЁЛ УРЛАГ, БИЕИЙН ТАМИР	11
 АМЬДАРЧ БУЙ ОРЧИН	12
 ГЭМТ ХЭРЭГ	12-13
 ТӨСӨВ	13
 ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ	14-15
 АЖ ҮЙЛДВЭР	15-16
 ГАЗАР ТАРИАЛАН	17
 ХАРИЛЦАА ХОЛБОО	17-18
 АЮУЛГҮЙ БАЙДАЛ	18-20

ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 1. Дүүргийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний Х сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2014	2015	2016	2017	2018
Суурин хүн ам, жилийн эцэст	тоо	34 547	35 813	36 425	36 911	-
Шинээр төрсөн хүүхэд	тоо	835	860	745	686	749
Ажилгүйчүүд, сарын эцэст	тоо	1 049	861	744	204	198
Үүнээс: эмэгтэй	тоо	594	659	401	121	123
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	527	778	786	424	378
Бүртгэсэн гэмт хэрэг	тоо	279	370	417	377	383
Орон нутгийн төсвийн орлого	сая төгрөг	12 905.5	12 818.4	14 681.1	13 832.5	15 744.8
Орон нутгийн төсвийн зарлага	сая төгрөг	12 241.5	12 590.0	14 128.1	13 393.2	14 437.7

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

Хүснэгт 2. Дүүргүүдийн эдийн засаг, нийгмийн байдлын харьцуулсан үзүүлэлт

	Хэмжих Нэгж	2017 оны X сард				2018 оны X сард					
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	298	Баянгол	7389	Налайх	54	306	Баянгол	7 630	Налайх	54
			Чингэлтэй	1797	Багануур	47		Чингэлтэй	1 808	Багануур	47
			Сүхбаатар	138	Багахангай	30		Сүхбаатар	671	Багахангай	30
Ажилгүйчүүд хөдөлмөрийн насны 10 000 хүнд ногдох	0\000**	79	Багахангай	621	Хан-Уул	67	115	Багахангай	574	Хан-Уул	70
			Багануур	283	Чингэлтэй	64		Багануур	212	Налайх	61
			Сүхбаатар	132	Сонгинохайрхан	59		Баянзүрх	189	Баянгол	56
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	13	Багахангай	25	Баянзүрх	11	11	Налайх	14	Чингэлтэй	10
			Налайх	15	Чингэлтэй	7		Багахангай	14	Баянзүрх	10
			Багануур	14	Баянгол	6		Хан-Уул	11	Баянгол	9
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	168	Баянзүрх	190	Багануур	122	115	Багануур	161	Сонгинохайрхан	103
			Сүхбаатар	149	Налайх	118		Баянзүрх	146	Сонгинохайрхан	100
			Чингэлтэй	146	Багахангай	34		Сүхбаатар	111	Багахангай	29
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	74	Чингэлтэй	99	Багануур	10	71	Сүхбаатар	75	Багануур	13.1
			Сүхбаатар	73	Налайх	8		Чингэлтэй	66	Налайх	10
			Хан-Уул	43	Багахангай	6		Хан-Уул	55	Багахангай	6
18-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	192	Сүхбаатар	324	Хан-Уул	142	238	Сүхбаатар	409	Сонгинохайрхан	147
			Баянзүрх	218	Багахангай	117		Баянзүрх	296	Багануур	112
			Чингэлтэй	208	Багануур	114		Баянгол	265	Багахангай	86

Тайлбар: * - промилль

** - продицимль

Эх үүсвэр: “Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2018 оны X сарын танилцуулга



ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Дүүргийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа 198 иргэн байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6 хүнээр (2.9%) буурсан ба 62.1 хувь нь эмэгтэйчүүд эзлэж байна.

Бүртгэлтэй нийт ажилгүйчүүдийн 19.2 хувь нь 15-24 насны залуучууд, 35.8 хувь нь 25-34 насныхан, 25.2 хувь нь 35-44 насныхан, 17.2 хувь нь 45-54 насны, 2.0 хувь нь 55-59 насны, 0.5 хувь нь 60 түүнээс дээш насны, түүнээс 1.0 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй адил байна.

Хүснэгт 3. Дүүргийн ажилгүйчүүд, насны бүлэг, хүйсээр, жил бүрийн эхний X сард

Үзүүлэлт	2015		2016		2017		2018	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Ажилгүйчүүд	861	659	744	401	204	121	198	123
Насны бүлгээр:								
15-24	148	97	93	46	37	21	38	26
25-34	316	250	283	153	93	61	71	48
35-44	216	172	188	104	48	25	50	31
45-54	134	102	125	70	21	13	34	18
55-59	34	26	32	19	5	1	4	-
60 +	13	12	23	9	-	-	1	-
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	18	11	29	11	3	2	2	-

Хүснэгт 4. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо				Дүнд эзлэх хувь			
	2015 I-X	2016 I-X	2017 I-X	2018 I-X	2015 I-X	2016 I-X	2017 I-X	2018 I-X
Ажилгүйчүүд, бүгд	861	744	204	198	100.0	100.0	100.0	100.0
Үүнээс:								
Магистр, доктор	2	3	2	1	0.2	0.5	1.0	0.5
Дипломын болон бакалавр	154	123	67	60	17.9	17.1	32.8	30.3
Тусгай мэргэжлийн дунд	60	52	11	8	7.0	6.9	5.4	4.0
Техникийн болон мэргэжлийн	96	78	21	13	11.1	10.6	10.3	6.6
Бүрэн дунд	435	378	80	104	50.5	50.6	39.2	52.5
Суурь	84	75	19	11	9.8	9.8	9.3	5.6
Бага боловсрол	23	21	2	1	2.7	2.7	1.0	0.5
Боловсролгүй	7	14	2	-	0.8	1.8	1.0	-

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс



ИРГЭНИЙ БҮРТГЭЛ


2018 оны эхний X сард 749 хүүхдийг иргэний бүртгэлд бүртгэн авч, нас барсан 228 хүнийг бүртгэлээс хасаж, 195 гэрлэлт, 39 хосын гэр бүл цуцлалтыг тус тус бүртгэсэн байна.

Шинээр мэндэлсэн хүүхдийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 63 хүүхдээр (9.2%), нас баралт өмнөх оны мөн үеэс 16 (7.5%) тус тус өссөн байна. Нийт мэндэлсэн хүүхдийн 52.0 хувь нь хүү, 48.0 хувь нь охин байна. Нийт нас баралтад 65.8 хувь нь эрэгтэй, 34.2 хувь нь эмэгтэй хүн эзлэж байна.

Хүснэгт 5. Төрөлт, нас баралтын бүртгэл, жил бүрийн эхний X сард

Үзүүлэлт		2015	2016	2017	2018
Төрсөн хүүхэд, бүгд		788	745	686	749
Үүнээс:	Эрэгтэй	394	372	370	389
	Эмэгтэй	394	373	316	360
Нас баралт, бүгд		220	206	212	228
Үүнээс:	Эрэгтэй	136	132	130	150
	Эмэгтэй	84	74	82	78

Зураг 1. Хүн амын ердийн цэвэр өсөлт



Хүснэгт 6. Гэрлэлтээ бүртгүүлсэн хос, насны бүлгээр, жил бүрийн эхний X сард

Үзүүлэлт	2016			2017			2018		
	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	эмэгтэй
Нийт	316	158	158	374	187	187	390	195	195
18-19	3	-	3	3	2	1	4	1	3
20-24	86	38	48	74	28	46	83	30	53
25-29	120	62	58	162	81	81	166	85	81
30-34	51	28	23	56	35	21	74	44	30
35-39	28	16	12	30	14	16	20	13	7
40-44	14	5	9	22	12	10	18	9	9
45-49	7	5	2	18	9	9	10	6	4
50 +	7	4	3	9	6	3	15	7	8

2018 оны эхний 10 сард гэрлэлтээ бүртгэлийн байгууллагаар баталгаажуулсан 195 хос байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8 (4.3%) өссөн. Хосууд тайлант онд гэр бүл болон бүртгэлээ хийлгэсэн байна. Бүртгүүлсэн нийт гэр бүл бологч хүнийг насны бүлгээр нь ангилбал 1.0% нь 18-19 насны, 21.3% нь 20-24 насны, 42.6% нь 25-29 насны, 19.0% нь 30-34 насны залуучууд, 5.1% нь 35-39 насны, 4.6% нь 40-44 насны, 2.6% нь 45-49 насны 3.8% нь 50-аас дээш насныхан байна.

Хүснэгт 7. Гэр бүл цуцлалт, жил бүрийн эхний X сард

Үзүүлэлт		2015	2016	2017	2018
Гэр бүл цуцлалт, бүгд		39	52	41	39
Гэр бүл байсан хугацаагаар (жилээр)	1 хүртэл	2	-	3	-
	1-3	4	2	5	-
	4-6	5	6	5	7
	7-9	15	13	7	7
	10-14	3	15	12	13
	15-19	5	3	3	3
	20 ба түүнээс дээш	5	13	6	9

2018 оны эхний 10 сард нийт 39 хос гэр бүлээ цуцлуулсан байна. Гэр бүл байсан хугацаагаар нь ангилбал, 18.0% нь 4-6 жил, 18.0 % нь 7-9 жил, 33.3% нь 10-14 жил, 7.6% нь 15-19 жил, 23.1% нь 20-оос дээш жил ханилсан хосууд байжээ.

Дүүргийн хэмжээнд бүртгэгдсэн гэр бүл цуцлалтын үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 (4.9%) буурсан байна. Дүүрэгт 2018 оны эхний 10 сард үрчлэгдсэн 5 хүүхэд байгаагийн 2 нь эрэгтэй, 3 нь эмэгтэй хүүхэд байна.

Хүснэгт 8. Үрчлэлтийн үзүүлэлт, жил бүрийн эхний X сард

Үзүүлэлт		2015	2016	2017	2018
Үрчлэгдсэн хүүхэд, бүгд		11	11	13	5
Үүнээс: насны бүлгээр					
3 хүртэл		4	5	10	2
3-6		2	2	1	3
7-9		1	1	-	-
10 ба түүнээс дээш		4	3	2	-

Эх үүсвэр: Налайх дүүргийн Улсын бүртгэл, оюуны өмчийн хэлтэс



НИЙГМИЙН ДААТГАЛ

2018 оны эхний X сард нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 8032.9 сая төгрөгт хүрч, нийгмийн даатгалын санд төвлөрчээ.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн 3580.1 сая төгрөг (44.6%) нь аж ахуйн нэгж, байгууллага, 3763.7 сая төгрөг (46.9%) нь төсөвт байгууллага, 155.4 сая төгрөг (1.9%) нь эрүүл мэндийн даатгал, 73.0 сая төгрөг (0.9%) нь

үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах, 460.7 сая төгрөг (5.7%) нь нөхөн шимтгэл, сайн дурын даатгуулагчдын шимтгэл байгаа юм.

Нийгмийн даатгалын сангаас эхний X сард 52904 даатгуулагч иргэнд 19280.8 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон байна.


Хүснэгт 9. Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт

Үзүүлэлт	2017 I-X		2018 I-X	
	Даатгуулагчдын тоо	Олгосон дүн (сая төгрөг)	Даатгуулагчдын тоо	Олгосон дүн (сая төгрөг)
Нийт орлого	-	7 135.7	-	8 032.9
Нийт зардал	150 617	19 560.4	52 904	19 280.8
Тэтгэврийн даатгалын сан	45 952	14 364.9	47 032	16 068.9
Өндөр насны тэтгэвэр	31 426	9 887.4	32 463	11 057.5
Тахир дутуугийн тэтгэвэр	7 608	1 735.7	7 609	1 904.1
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	2 934	674.7	2 714	746.0
Цэргийн тэтгэвэр	3 984	2 067.1	4 246	2 361.3
ҮОМШӨ-ний даатгалын сан	5 089	2 243.6	4 328	2 259.2
Тахир дутуугийн тэтгэвэр	4 559	2 107.5	3 898	2 116.1
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	297	104.7	255	107.8
Сувиллын зардал	222	27.7	143	18.6
ҮОМШӨ ХЧТА ¹	11	3.7	32	16.7
Тэтгэмжийн даатгалын сан	1 118	593.3	1 319	657.5
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	582	53.3	750	76.3
Жирэмсний амралт	373	377.0	405	417.2
Оршуулга	163	163.0	164	164.0
Ажилгүйдлийн даатгалын сан	171	238.5	225	295.0
Ажилгүйдлийн тэтгэмж	171	238.5	225	295.0
Эрүүл мэндийн даатгалын сан	98 287	2 120.0	-	-
Эмчилгээ үйлчилгээний зардал	86 305	1 774.6	-	-
Эмийн үнийн хөнгөлөлт	11 982	345.4	-	-

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс

¹ Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн чадвараа түр алдсан

Зураг 2. Даатгалын сангийн зарлага



Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо оны эхний Х сард 42786, олгосон тэтгэврийн хэмжээ 16068.9 сая төгрөгт хүрчээ. Олгосон нийт тэтгэврийн 68.8 хувийг өндөр настны 11.9 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 4.6 хувийг тэжээгчээ алдсан, 14.7 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.



НИЙГМИЙН ХАЛАМЖ

2018 оны эхний Х сард давхардсан тоогоор нийт 7699 хүнд халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж үйлчилгээ үзүүлж, халамжийн зардлын хэмжээ өссөн дүнгээр 4822.7 сая төгрөг болсон байна.

Хүснэгт 10. Нийгмийн халамжийн үйлчилгээний үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	2016		2017		2018	
	Хүний тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)	Хүний тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)	Хүний тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)
	Х	I-X	Х	I-X	Х	I-X
Халамжийн орлого, бүгд	-	2 779.8	-	3 399.0	-	4 848.2
Зарцуулалт, бүгд	4 558	2 748.5	7 531	3 213.7	7 699	4 822.7
Халамжийн тэтгэвэр	1 718	1 063.2	-	1 067.2	-	1 182.7
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	632	312.4	-	355.0	-	451.2
Ахмад настны хөнгөлөлт	70	197.8	1 349	300.8	-	393.6
Халамжийн үйлчилгээ	10	180.6	-	0.5	-	-
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд	47	56.2	317	79.7	-	82.4

Хүснэгт 10-ын үргэлжлэл

Үзүүлэлт	2016		2017		2018	
	Хүний тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)	Хүний тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)	Хүний тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)
	X	I-X	X	I-X	X	I-X
Эхчүүдийн мөнгөн тэтгэмж	932	347.2	1 413	309.0	977	130.9
Алдарт эхийн одонгийн тусламж	1	345.9	2 736	357.2	2 756	357.8
Алдар цолтой ахмад настнуудад олгосон	10	17.6	12	20.4	13	21.4
Хүнс тэжээл хөтөлбөрийн зардал	1 120	199.6	-	201.4	-	703.8
Амьжиргааг дэмжих зөвлөл	18	4.2	52	6.6	56	5.5
Насны хишгийн зардал	-	-	1 652	252.1	1 697	260.1
Цалинтай ээж хөтөлбөр	-	-	-	-	2 200	857.4
Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	-	-	-	223.5	-	267.9
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	-	15.0	-	37.5	-	24.5
Өрх толгойлсон эцэг эхийн хөтөлбөр	-	-	-	-	-	81.5
Судалгааны зардал	-	5.5	-	1.2		
Бусад зардал	-	3.2	-	1.6		2.0

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс



ЭРҮҮЛ МЭНД

2018 оны эхний X сард төрсөн эхийн тоо өмнөх оны мөн үеэс 68 (10.3%), нас баралт 37 (18.5%) тус тус өссөн байна.

Хүснэгт 11.Төрөлт жил бүрийн эхний X сард

Үзүүлэлт	2015	2016	2017	2018
Амаржсан эхийн тоо, бүгд	860	726	658	726
Амьд төрсөн хүүхэд	862	727	666	734
Амьгүй төрсөн	7	6	6	7
Эхийн эндэгдэл	-	-	-	-
Нас баралт	199	185	200	237
Үүнээс: нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	11	16	10	10
Эмнэлгийн нөхцөлд гарсан нас баралт	18	30	16	15
Гэрийн нөхцөлд гарсан нас баралт	148	129	163	181
Улаанбаатар хотод бүртгэгдсэн нас баралт ²	33	26	21	41

² Дүүргийн харьяат иргэдээс Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хэвтэн эмчлүүлж байгаад гарсан нас баралт

2018 оны эхний X сард бүртгэгдсэн нийт нас баралтын 76.4 хувийг гэрийн орчин нөхцөлд гарсан нас баралт эзэлж байгаа бол 17.3 хувийг Улаанбаатар хотод хэвтэн эмчлүүлж байгаад гарсан, 6.3 хувь хувийг дүүргийн эмнэлэгт гарсан нас баралт эзэлж байна.

Хүснэгт 12. Дүүргийн хэмжээнд гарсан халдварт өвчин, жил бүрийн эхний X сард

Үзүүлэлт	2015	2016	2017	2018
Нийт халдварт өвчин	778	786	424	378
Халдварт өвчин:	249	402	106	106
Хепатит В вирус	4	7	1	2
Хепатит С вирус	-	-	1	-
Халдварт шар	-	-	-	-
Менинжет	-	-	1	1
Салхин цэцэг	52	28	21	53
Гахайн хавдар	-	1	-	-
Паротит	3	1	-	5
Бруцеллез	-	1	-	-
Ёлом	3	-	3	2
Дизентери	6	2	10	12
Гар, хөл, амны өвчин	7	42	60	18
Хоолны хордлого	1	6	-	1
Сальмонеллөз	4	3	-	2
Энтеровируст халдвар	-	-	-	-
Улаан бурхан	167	304	-	-
Улаан эсэргэнэ	-	3	6	5
Эритема	-	1	-	2
Нярайн бактер үжил	1	-	-	-
Экзантема сабитум	-	-	-	2
Хачигт риккетиз	1	2	-	-
Хачигт энцефалит	-	-	-	-
6 дахь өвчин	-	2	3	-
Скарлатин	-	-	-	1
Сүрьеэ	42	58	40	48
Арьс өнгөний өвчин	487	326	278	224
Тэмбүү	126	80	64	84
Үүнээс: төрөлхийн	1	-	-	-
Заг хүйтэн	42	43	76	41
Хамуу	2	-	-	-
Бэлгийн замын мөөгөнцөр	220	77	76	45
Мөөгөнцөр	23	12	7	-
Трихомониаз	74	114	55	54


Эх үүсвэр: Эрүүл мэндийн төв

Эрүүл мэндийн үзүүлэлтээр дүүргийн хэмжээнд халдварт өвчнөөр 106 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үетэй ижил байна. Арьс өнгөний өвчлөл 224 гарсан нь 54 (19.4%) хүнээр бүүрч, сүрьеэгээр 48 хүн өвчилсөн нь 8 (20.0%) тохиолдлоор өссөн байна. Нийт халдварт өвчний гаралт 378 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 46 (10.8%) буурсан байна.

Хүснэгт 13. Эмнэлгийн үзлэгийн үзүүлэлт, жил бүрийн эхний X сард

Үзүүлэлт	2015	2016	2017	2018
Урьдчилан сэргийлэх тарилга	5 853	5 300	6 588	6 081
Амбулаторын үзлэг	176 621	161 112	161 528	178 369
Ор хоног	39 728	35 962	38 133	42 756
Эмчийн тоо	72	72	69	75
Сүвилагчийн тоо	104	104	104	98
Орны тоо	165	165	177	227

Зураг 3. Эмнэлгийн үзлэгийн үзүүлэлт



Амбулаторийн үзлэгийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд 16841 (10.4%), ор хоног 4623 (12.1%) өссөн байна. Урьдчилан сэргийлэх тарилга 507 (7.7%) буурсан байна.



СОЁЛ УРЛАГ

Дүүргийн соёл, урлагийн байгууллага 2018 оны эхний X сард нийтдээ 5 төрлийн 123 ажил, үйлчилгээг явуулж, 14438.6 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна.

Хүснэгт 14. Соёл, урлагийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний X сард

Ажил үйлчилгээ	Нийт	Үүнээс:					Номын сан (уншигчид)	Музейн ³ үзэгчид
		Урлагийн тоглолт	Хурал цуглаан	Кино үзвэр	Уралдаан тэмцээн	Дугуйлан сургалт		
Бүгд	123	37	45	21	10	10	1 407	1 206

Эх үүсвэр : Соёл урлагийн ордон

³ Орон нутаг судлах танхим



АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

2018 оны эхний Х сард хот тохижилтын ажил үйлчилгээний нийт орлого 194.9 сая төгрөг болж, орлогын 21.0 хувийг орон сууц, 28.2 хувийг гэр хороолол, 50.8 хувийг аж ахуйн нэгжээс хуримтлуулсан орлого эзэлж, нийтдээ 61.3 мянган тонн хогийг зөөж, тээвэрлэсэн байна.

Хүснэгт 15. Хот тохижилтын үзүүлэлт, жил бүрийн эхний Х сард

Үзүүлэлт	2016	2017	2018	Үүнээс:		
				Орон сууцны	Гэр хороолол	ААНБ
Нийт орлого, сая төгрөг	231.1	273.4	194.9	41.0	54.9	99.0
Хог тээвэрлэлт, мянган тонн	39.6	29.1	68.6	14.6	33.0	21.0

Эх үүсвэр: Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар

Хүснэгт 16. Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ, жил бүрийн эхний Х сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015	2016	2017	2018
Шахсан ус	мянган м ³	1 054.2	984.6	826.8	803.6
Борлуулсан ус	мянган м ³	503.0	437.5	307.5	319.4
Үүнээс: Хүн амд	мянган м ³	283.0	219.6	185.4	211.6
Аж ахуйн нэгж байгууллагад	мянган м ³	220.1	217.9	122.1	107.8
Татан зайлуулсан бохир	мянган м ³	383.5	279.0	275.4	307.1
Ус борлуулалтын орлого	сая төгрөг	615.1	810.9	327.6	377.5
Сувагжуулалтын орлого	сая төгрөг	283.7	270.3	53.9	278.2
Халаалтын орлого	сая төгрөг	127.9	212.1	65.7	72.8

Эх үүсвэр: Чандмань Налайх ОНӨААТҮГазар

2018 оны эхний Х сард дүүргийн хэмжээнд 319.4 мянган м³ ус борлуулснаас, 211.6 мянган м³ (66.2%) усыг хүн амд, 107.8 мян.м³ (33.8%) усыг аж ахуйн нэгж байгууллагад түгээсэн байна.

ГЭМТ ХЭРЭГ



Дүүрэгт 2018 оны эхний Х сард 383 гэмт хэрэг гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6 гэмт хэргээр (1.6%) өсөж, гэмт хэргийн илрүүлэлт 36.0 хувьтай байна.


Дээрх 383 гэмт хэрэгт 182 сэжигтэн яллагдагч холбогдсон бөгөөд насны ангиллаар авч үзвэл, 15 хүртэлх насны 2, 16-17 насны 7, 18-24 насны 42, 25-29 насны 32, 30-34 насны 38, 35-39 насны 23, 40-44 насны 17, 45-49 насны 10, 50-54 насны 3, 55-59 насны 4, 60-64 насны 2, 65-69 насны 2 хүн байна.

Хүснэгт 17. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, жил бүрийн эхний X сард

Үзүүлэлт		2015	2016	2017	2018
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд		370	417	377	383
Хүн амины	Санаатай	6	2	4	3
	Учрал	4	10	9	8
	Бусдыг болгоомжгүй алах	1	-	2	-
Хүчин		2	2	2	3
Дээрэм		3	2	2	6
Танхай		12	12	19	-
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх		-	-	-	7
Хулгай	Иргэдийн өмчийн	70	121	115	133
	Малын	11	7	9	11
	Халаасны хулгай	-	-	-	1
	Аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн	1	2	4	
	Автомашины	-	-	-	1
Булаалт		1	1	-	
Залилан		10	13	19	22
Бусдын бие махбодид гэмтэл учруулсан		153	161	136	132
Авто тээвэр		22	21	19	17
Бусад		74	63	37	32
Илрүүлээгүй гэмт хэргийн тоо		32	47	184	229
Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь		67.7	70.4	51.2	36.0
Гэмт хэрэгт холбогдогчид, бүгд		355	402	197	182
Үүнээс:	Ажилгүй	225	278	144	108
	Албан хаагч	23	25	7	14
	Сурагч	4	10	4	-
	Оюутан	11	6	2	7
	Малчин	8	2	2	1
	Тэнэмэл иргэд	2	-	-	1
	Төрийн бус байгууллагын ажилтан	2	3	1	9
	Хугацаат цэргийн алба хаагч	-	-	1	
	ХХЭ болон хувийн хэвшилд ажиллагч	80	78	36	42
Эрүүлжүүлэгдсэн хүн		3 040	2 440	2 318	2 640

Эх үүсвэр: Цагдаагийн хэлтэс

Зураг 4. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороодоор



Гэмт хэргийн улмаас 19 хүн нас барж, 139 хүн гэмтэж бэртсэн бөгөөд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нийтдээ 842.4 сая төгрөгийн хохирол учруулсны 353.8 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн байна.

2018 оны эхний 10 сард 15201 зөрчил илрүүлж, 14208 хүнийг 353.8 сая төгрөгөөр торгож, 2640 (эмэгтэй 320) хүнийг эрүүлжүүлж, 17 хүнийг архины албадан эмчилгээнд явуулж, 414 хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг

хасаж, 37 хүнийг шүүхийн шийдвэрээр баривчлуулжээ. 7 гэмт хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

2018 оны эхний X сард гарсан гэмт хэргийн гаралт 1-р хороонд 83 гарч хамгийн өндөр байхад 4-р хорооны нутаг дэвсгэрт 25 буюу гэмт хэргийн гаралт хамгийн бага байна.




ТӨСӨВ

2018 оны эхний X сард дүүргийн төсөвт 1438.0 сая төгрөгийн татварын орлого төвлөрч, төлөвлөгөө 443.4 сая төгрөгөөр (6.5%) давж биелэв.

Татварын орлогын 46.5 хувийг хүн амын орлогын албан татвар, 16.8 хувийг хог хаягдлын үйлчилгээний хураамж, 0.4 хувийг бууны татвар, 0.8 хувийг ус, рашаан ашигласны төлбөр, 3.2 хувийг түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, 6.7 хувийг улсын тэмдэгтийн хураамжийн орлого, 25.6 хувийг хүү торгуулийн орлого тус тус бүрдүүлсэн байна.

Зураг 5.Орон нутгийн татварын орлого бүрдэлт



Эх үүсвэр: Татварын хэлтэс



ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ

Түүхий эд худалдан авах үнэ өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэмээний шир, адууны шир, үхрийн шир, хонины арьс, ямааны арьсны үнэд өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт 18. Зарим түүхий эдийн үнэ, жил бүрийн эхний X сард


Түүхий эдийн нэр	Хэмжих нэгж	2015	2016	2017	2018
		төгрөг			
Тэмээний шир	ширхэг	20 000	15 000	20 000	20 000
Адууны шир	ширхэг	35 000	30 000	18 000	18 000
Үхрийн шир (дундаж үнэ)	1.8-2.3 метр хэмжээтэй ширхэг	39 000	30 000	31 000	31 000
Хонины арьс	ширхэг	2 000	2 500	5 500	5 500
Ямааны	ширхэг	9 000	-	20 000	20 000

Хүснэгт 19. Нэг литр шатахууны үнэ, төгрөг

ШТС	2017.X.27					2018.X.31				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Жаст Ойл	1 820	-	1 630	1 720	-	-	1 780	1 950	2 220	-
Петровис	1 820	1 480	1 630	1 720	-	2 345	1 845	1 985	2 385	-
Магнай трейд	1 820	1 480	1 630	1 720	-	2 340	1 749	1 980	2 380	-
Сод монгол	1 820	-	1 630	1 720	-	2 300	-	1 980	2 380	-
Шунхлай	-	-	1 630	1 720	-	2 320	1 850	1 985	2 385	-
Юнигаз	-	-	-	-	1 050	-	-	-	-	1 300
Дундаж үнэ	1 820	1 480	1 630	1 720	1 050	2 326	1 806	1 976	2 350	1 300

Эх үүсвэр: Нийслэлийн статистикийн газрын 7 хоногийн үнийн судалгааны дүн

Зураг 6. Нэг литр шатахууны дундаж үнэ X сард



АЖ ҮЙЛДВЭР

2018 оны эхний X сард үйлдвэрлэгдсэн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад цахилгаан эрчим хүч 10.3%, усан хангамж 29.0 хувиар өсөж, дулаан хангамж 8.3 хувиар буурсан байна. Уул уурхайн олборлолтын салбарын хувьд нүүрс олборлолт 75.0 хувиар буурсан байна. Элс 8.2 хувиар, шохойн чулуу 16.8 хувиар тус тус өссөн байна.

Боловсруулах үйлдвэрийн хувьд тоосгоны үйлдвэрлэлт 9.5 хувиар, цемент 30.8 хувиар, оёдол 28.4 хувиар өссөн, барилгын зориулалттай замасканы үйлдвэрлэлт 2.6 дахин, хар замаска 3.4 дахин, плитаны цавуу 22.9 хувиар тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад цахилгаан эрчим хүч 15.1%, дулаан хангамж 28.8%, усан хангамж 10.1%, цементийн борлуулалт 30.1%, элсний борлуулалт 7.5%, тоосго 44.7% тус тус өссөн байна. Барилгын зориулалттай замасканы борлуулалт 2.3 дахин, хар замасканы борлуулалт 2.4 дахин, плитаны цавууны борлуулалт 32.5 хувиар тус тус өссөн байна. Шохойн чулууны борлуулалт 4.1 хувиар буурсан, Харин нүүрсний борлуулалт 78.3 хувиар, оёдлын үйлдвэрлэлт 44.5 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 20. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, эхний X сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Нийт үйлдвэрлэлт					
		Биет хэмжээгээр			Үнийн дүнгээр, сая төгрөг		
		2016	2017	2018	2016	2017	2018
Эрчим хүчний үйлдвэр:							
Цахилгаан	сая.квт.цаг	101.7	126.7	139.7	15 456.8	19 156.8	22 047.7
Дулаан	мянган гкал	83.4	84.5	77.5	2 031.3	2 037.3	2 625.5
Усан хангамж	мянган м ³	1 060.0	1 243.0	1 604.0	678.6	385.6	424.7
Олборлох үйлдвэр:							
Шохой	тонн	38.5	24.4	28.5	362.1	268.3	257.4
Нүүрс	мянган тонн	2.1	1.0	0.25	96.0	67.5	14.6
Хайрга	мянган м ³	7.0	-	-	128.5	-	-
Элс	мянган м ³	14.3	33.7	36.45	94.1	244.2	262.5
Боловсруулах үйлдвэр:							
Тоосго	мянган ширхэг	13 137.0	11 163.0	12 225.0	1 245.4	1 235.1	1 787.4
Цемент	мянган тонн	28.6	18.7	24.46	3 891.0	2 680.2	3 486.3
Шохой	тонн	-	-	21	-	-	1.7
Оёдол	мянган ширхэг	9.3	21.5	27.6	413.1	473.2	262.3
Гэр ахуйн оёмол эдлэл	мянган ширхэг	-	-	3.8	-	-	54.4
Арьсан цүнх, түрийвч эдлэл	мянган ширхэг	-	-	75.8	-	-	404.4
Замаска	тонн	-	44.1	116.8	-	12.9	30.0
Барилгын шавардлагын хар замаска	тонн	-	71.1	245.2	-	20.6	49.3
Плитаны цавуу	тонн	-	65.5	80.5	-	20.3	26.9
Резинэн эдлэл	сая төгрөг	-	-	5.5	-	-	5.5
Хэвлэлийн хор	мянган ширхэг	-	-	37.4	-	-	613.0
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл:							
Талх	тонн	5.3	-	44.21	4.9	-	85.0
Нарийн боов, жигнэмэг	тонн	-	-	26.97	-	-	58.8
Хэрчсэн гурил	тонн	-	-	0.82	-	-	0.8
Бүх төрлийн ногооны консерв	тонн	-	-	1.5	-	-	8.0
Эмчилгээний цай	килограмм	-	-	1353	-	-	41.4
Хүүхдийн тэжээл	тонн	-	-	0.018	-	-	1.2
Чипс	тонн	-	-	40	-	-	1.7
Цэвэр ус	мянган литр	-	-	16.3	-	-	8.9

Эх үүсвэр: Дүүргийн аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа тогтмол явуулсан ААН-ын дүнгээр

Ургац хураалт : Дүүргийн хэмжээнд 2018 оны 10 сард ургац хураалтын мэдээгээр нийт 8.57 га талбайгаас 59.38 тн төмс, 8.2 га талбайгаас 53.638 тн хүнсний ногооны ургац хураан авч, 1969.25 тн өвс, хадлан бэлтгэсэн байна.

Хураасан төмс өмнөх оны мөн үеэс 15.673 (64.6%) тонноор , хүнсний ногоо 9.8392 (54.6%) тонноор тус тус буурсан байна.

Хүснэгт 21. Дүүргийн ургац хураалт, жил бүрийн Х сард

Нэр төрөл	2017 Х			2018 Х		
	Хураасан талбай(га)	Хураасан ургац, (тн)	Хорогдол (тн)	Хураасан талбай(га)	Хураасан ургац, (тн)	Хорогдол (тн)
Төмс	24.243	128.77	1.5	8.57	59.38	-
Хүнсний ногоо	18.01	106.6278	1.917	8.1708	53.638	-
Байцаа	3.9	20.417	0.235	1.9502	9.593	-
Лууван	3.209	20.58	0.01	1.926	15.379	-
Шар манжин	3.298	18.825	0.01	2.1069	8.072	-
Улаан манжин	1.5918	10.791	0.0092	0.5781	3.76	-
Сонгино	1.2622	7.51	-	0.5938	5.629	-
Сармис	0.41	1.35	-	0.0143	0.218	-
Хүлэмжинд нийт	4.339	27.1548	1.6528	1.0015	10.987	-
Өргөст хэмх	1.9077	13.29	0.002	0.2155	3.638	-
Улаан лооль	0.8869	4.8428	0.0008	0.4294	4.091	-
Тарвас	0.028	0.12	-	0.0008	0.3	-
Хулуу	-	-	-	0.0014	0.101	-
Чинжүү	0.11	0.422	-	0.1067	0.351	-
Бусад	1.4064	8.48	1.65	0.2477	2.506	-
Бэлтгэсэн өвс	1796.15	1796.15	-	1969.25	1969.25	-
Өөрсдийн бэлтгэсэн	420.5	420.5	-	1086.25	1086.25	-
Худалдаж авсан	1375.65	1375.65	-	883.0	883.0	-
Бэлтгэсэн дарш	-	-	-	5.57	5.57	-
Сүрэл	2	2	-	-	-	-
Гар тэжээл	65.94	65.94	-	71	71	-
Хужир шүү	11.375	11.375	-	10.69	10.69	-

Эх үүсвэр: Хороодын ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэлийн IX сарын мэдээ

МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО



Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа холбооны байгууллага 207.4 сая төгрөгийн орлоготой ажиллаж, үүнээс 101.6 сая төгрөг (49.0%) нь хүн амд үзүүлсэн үйлчилгээний орлого эзэлж байна.

Телефон цэгийн тоо өмнөх оны мөн үеэс 12 (2.1%) өссөн байна. Нийт

суурин телефон цэгийн 332 (56.0%) нь айл өрхийн эзэмшилд байгаа бол 195 (32.9%) нь төсвийн байгууллагад, 66 (11.1%) нь бизнесийн байгууллагуудад ашиглагдаж байна.

Хүснэгт 22. Харилцаа холбооны салбарын үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний Х сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015	2016	2017	2018
Нийт орлого	сая төгрөг	167.0	170.6	184.3	207.4
Үүнээс: хүн амд үзүүлсэн үйлчилгээний	сая төгрөг	81.8	83.6	90.3	101.6
Телефон цэг	тоо	606	595	581	593
Үүнээс: айл өрх	тоо	345	357	345	332
Интернет үйлчилгээний цэг	тоо	2	2	2	2
Интернет үйлчилгээний суудал	тоо	20	20	20	20
Интернет үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчид	тоо	17 277	10 374	9 560	5 097
Интернетийн байнгын хэрэглэгчид	тоо	194	282	481	358
Таксофон	тоо	1	1	1	1

Хүснэгт 23. Кабелийн телевизийн үзүүлэлт, жил бүрийн эхний Х сард

Үзүүлэлт/он	хэмжих нэгж	2015	2016	2017	2018
КТВ-ийн орлого	мян.төг	63 621.8	258 809.8	133 803.0	96 945.0
Хэрэглэгч	тоо	4760	6728	2280	3575

Хүснэгт 24. Газартай холбоотой асуудал шийдвэрлэлт, жил бүрийн эхний Х сард

Зориулалт	Газрын хэмжээг өөрчлөх	Газар эзэмших эрхийг хүчингүй болгох	Газар эзэмших эрх олгох	Газар эзэмших эрхийг шилжүүлэх	Газар өмчлөх	Хамтран өмчлөгч хасуулах	Газрын байршил өөрчлөх	Газар ашиглуулах эрх олгох
Иргэн, ААНБ-ын тоо	8	31	1 411	422	243	87	18	10

Эх үүсвэр: Өмч, газрын харилцааны алба

2018 оны эхний Х сард Нийслэлийн засаг даргын 6 удаагийн, дүүргийн Засаг даргын 68 захирамжаар нийт 2230 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газартай холбоотой асуудлыг шийдвэрлэсэн байна.



АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Дүүргийн Онцгой байдлын хэлтэс 2018 оны эхний Х сард гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг хийж, нийт 950 айл өрх, 366 аж ахуйн нэгж, байгууллагад 1146 зөрчил илрүүлэн, 235 зөрчлийг арилгуулан, гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 88, мэдэгдэл 160, зөрчлийн тэмдэглэл 60, дүгнэлт 19, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 111 хүргүүлсэн байна. Мөн объектын гал түймрийн 68 дуудлагаар ажиллаж, 533.0 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан байна.

Хүснэгт 25. Гал түймрийн дуудлагын тоо жил бүрийн эхний Х сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015	2016	2017	2018
Бүгд		70	88	71	68
Өмчийн хэлбэрээр:					
Төрийн өмч	тоо	16	13	7	5
Хувийн өмч	тоо	51	63	53	62
Аж ахуйн нэгж	тоо	3	10	11	1
Хамтын болон гадаад улсын өмч	тоо	-	2	-	-
Гал түймэрт өртөж шатсан:					
Нас барсан	хүүхэд	-	-	-	1
	том хүн	1	-	1	2
Түлэгдэж бэртсэн	хүүхэд	2	-	-	-
	том хүн	1	1	-	1
Өвөл зуны сууц	тоо	20	11	7	14
Гэр	тоо	10	12	14	12
Нийтийн орон сууц	тоо	-	-	2	-
Хог, хогийн суваг	тоо	21	24	18	18
Машин техник	тоо	5	7	7	4
Барилга байгууламж	тоо	1	4	8	3
Малын хашаа саравч	тоо	13	7	9	2
Шалтгаан:					
Цахилгааны	тоо	11	16	7	3
Ил задгай асгасан үнс, нурмаас	тоо	42	36	14	1
Лаа, тамхи, шүдэнз	тоо	-	-	6	16
Пийшин зуухны цоолт	тоо	6	13	4	-
Машин техник гэмтэл, буруу ашигласан	тоо	2	5	3	1
Машин, техникийн яндангийн оч болон цахилгааны очноос	тоо	2	-	-	-
Архидан согтуурснаас	тоо	-	-	-	3
Газрын тосны бүтээгдэхүүний ашиглалтын буруугаас	тоо	1	-	-	-
Бусад	тоо	1	4	2	-
Шалтгаан тогтоогдоогүй	тоо	5	14	35	44
Аварсан эд хөрөнгө:					
Хүн	тоо	1	-	-	1
Өвөл зуны сууц	тоо	10	8	9	10
Гэр	тоо	5	3	5	4
Барилга байгууламж	тоо	4	5	1	7
Машин техник	тоо	4	5	6	2
Нийтийн орон сууц	тоо	-	-	2	-
Улсын онц чухал болон галын онц аюултай объект	тоо	4	-	-	1
Малын хашаа саравч	тоо	6	1	7	-
Эд хөрөнгө	сая төгрөг	607.0	437.0	400.7	533.0

Эх үүсвэр: Онцгой байдлын хэлтэс



ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, ШИЙДВЭРЛЭЛТ

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг бүртгэх, шилжүүлэх, шийдвэрлэх, хариу өгөх, хяналт тавих, тайлагнах ажлыг “Өргөдөл, гомдлын нэгдсэн программ”-аар явуулж байгаагийн зэрэгцээ “Налайх сонсож байна” 7023-2727, 1800-1200 тусгай дугаарын утас, Засгийн газрын 11-11 утас, www.ub1200.mn цахим хуудас, Check my service аппликейшн зэргээр иргэдийн гомдол, хүсэлт, саналыг хүлээн авч байна.

2018 оны эхний X сард дүүргийн Засаг Даргын Тамгын газарт нийт 377 санал, хүсэлт, өргөдөл хүлээн авсан байна. Эдгээрээс 369 санал, хүсэлт, өргөдөлд хариу өгч, 8-д хариу өгөх хугацаа болоогүй болон судлагдаж байна. Санал хүсэлтийн шийдвэрлэлт 97.8 хувьтай байна. Ирсэн өргөдөл, гомдол, саналын 297 (76.5%) нь бичгээр, 80 (23.5%) нь утсаар ирсэн байна.

Эх үүсвэр: ЗДТГ-ын нэг цонхны үйлчилгээ

Танилцуулгыг татаж авах линк :

www.ubstat.mn
www.nad.ub.gov.mn
Налайх дүүргийн Статистикийн
хэлтэс facebook page

Утас: 7023-3672

УБ хот, Налайх дүүрэг ЗДТГ-ын байр 2 давхар 210 тоот